

Улсын Их Хурлын Тамгын Газар
Судалгаа, шинжилгээний хэлтэс

Код: СТ-13/230

***“Хүүхэд үрчлүүлэх болон хүүхэд үрчлэн авах талаар бусад
орны туршлага, эрх зүйн зохицуулалт”***

Харьцуулсан судалгаа

Захиалагч: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан

Гүйцэтгэсэн судлаач: Референт П.Нарантуяа

2013 он

ОРШИЛ

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангаас 2013 оны 5 дугаар сарын 31-ний 10/3794 тоотой ирүүлсэн *“Хүүхэд үрчлүүлэх болон хүүхэд үрчлэн авах талаар бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт”*-ын асуудлаар судалгаа хийлгэхээр ирүүлсний дагуу дараах харьцуулсан судалгааг хийв.

Хүүхэд хамгаалахтай холбоотой асуудал үрчлэлт гэдэг нь нэг талаараа төрсөн эцэг эхээсээ хагацсан, эцэг эх нь нас барсан хүүхдээ хаясан тохиолдолд тухайн хүүхдийг шинэ, байнга хамт байх гэр бүлтэй болгож байгаа явдал нь зөв шийдэл болдог гэж үздэгээс хүүхэд үрчлэх тухай асуудал гарч ирсэн.

Энэ асуудал бол маш нарийн зохицуулалт шаардсан хүний эрх, ялангуяа хүүхдийн эрхийг хөндсөн асуудал учраас насанд хүрээгүй хүн өөрийгөө хамгаалах чадваргүй байгааг онцгой авч үзэн хүүхдийн эрхийг дээдлэх зарчмыг асуудлын гол болгон авч үздэг. Асуудал нь өөрөө их эмзэг учраас заримдаа бэрхшээл учрах тал байна.

Хүүхэд үрчлэлтийн асуудалд олон чухал ажлуудыг санаачилан хэрэгжүүлж нааштай эерэг байдлаар хандан анхаарал татсан шинээр бий болж арга хэлбэр нь улам нарийсч байгаа сөрөг үр дагавруудыг арилгахын төлөө олон улс ихээхэн хүч чармайлт тавьсаар байна.

Үрчлэлт нь улс орны дотор төдийгүй улс хоорондоо үрчлэх асуудал байсан одоо ч байсаар байна. Улс дотроо хүүхэд үрчлүүлэх болон үрчлэх асуудлыг **дотоодын** гэх ба иргэний харьяаллаас үл хамааран өөр улсад амьдарч байгаа гэр бүлийн хос буюу ганц бие хүн өөр улсаас хүүхэд үрчилж авахыг **улс хоорондын үрчлэлт** гэнэ. Мөн зарим оронд хилийн чанадад амьдарч буй шилжин суурьшигч /цагаач/ иргэд өөрийн төрсөн нутгаас хүүхэд үрчилж авах явдал бас байгаа юм.

Харин Олон улсын хэмжээнд хүүхдийн эрхийн тухай энэ асуудлыг “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн 21.1-д тодорхой зааж, үрчлэлтийн тогтолцоо бүхий болон түүнийг хүлээн зөвшөөрсөн орнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон бөгөөд “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц”-д 70 гаруй тодорхой заалтаар хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан. Хүүхэд үрчлүүлэх болон үрчлэн авахтай холбоотойгоор:

- *Хүүхдийн эрхийн тухай 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенц,*
- *Хүүхэд хамгаалал, хүүхдийн аж байдлын талаар үндэсний болон улс хооронд хүүхдийг асрамжид шилжүүлэх нийгмийн болон эрх зүйн зарчмуудын тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын тунхаглал (Ерөнхий Ассамблейн 1986 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 41/85 тоот тогтоол)-ыг харгалзан үзэж нийтлэг ойлголт тогтоохыг эрмэлзэн 48 зүйлтэйгээр баталсан байна.*

Энэхүү Конвенцид гарын үсэг зурсан улсууд, хүүхдийг өв тэгш хөгжүүлэх үүднээс тэднийг гэр бүлийн болон баяр баясгалан, хайр, ойлголцлын орчинд өсгөн хүмүүжүүлэхийг хүлээн зөвшөөрч, улс бүр хүүхдийг төрсөн гэр бүлийн халамжинд байлгах зохистой арга хэмжээг тэргүүн ээлжинд авч хэрэгжүүлэхийг уриалж, төрөлх улсад нь үрчлэн авах тохиромжтой гэр бүл олдохгүй тохиолдолд хүүхдийг улс хооронд үрчлэх нь байнгын гэр бүлийн харгалзан үзсэнээр үрчлүүлж буй хүүхдэд тааламжтай байдал олгохыг хүлээн зөвшөөрч, улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, үндсэн эрхийг нь хүндэтгэж, хүүхэд худалдах, хулгайлах, хил дамнан худалдахаас сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатайг ухамсарлаж нэгдэн орсон байна.

Энэ баримт бичгийг 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Гааг хотноо Англи, Франц хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нэгэн адил хүчинтэй. Эх бичвэр Нидерландын Вант Улсын Засгийн газрын архивт баталгаажуулан хадгалагдсан.

Энэхүү баримт бичгийг 17 дугаар чуулганы үед олон улсын хувийн эрх зүйн асуудлаар байгуулагдсан Гаагийн бага хурлын гишүүн улсуудад мөн уг чуулганд оролцсон улс бүрт илгээжээ.

Хүүхдийн эрхийн конвенцид: Хүүхэд бүр төрсөн эцэг эхтэйгээ, гэр бүлийнхээ орчинд асран хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг. Гэвч нэгэнт гэр бүлгүй болсон, эсвэл ямар шалтгаанаар гэр бүлээсээ тусгаарлагдсан, хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд гэр бүл нь ноцтой аюул занал учруулж байгаа бол тухайн хүүхэд асран хамгаалахын өөр төрлийг эдлэх эрхтэйг онцлон авч үзсэн.

Хүүхдийн эрхийн конвенцийн 20 дугаар зүйлд асран хамгаалахын 4 төрлийг заасны нэг нь үрчлэлт юм. Үрчлэлт нь өөрөө өргөн утгатай үзэгдэл бөгөөд хувь хүн болон гэр бүлийн хооронд, ялангуяа эцэг, эх-хүүхэд гэсэн хууль зүйн хэлхээ холбоо бий болгохыг хэлнэ.

Монгол Улс дээрх конвенцид нэгдэн орсон төдийгүй энэ харилцааг гэр бүлийн тухай хуулийн 55.1-ийн 58, 59 дэх заалтаар зохицуулсан байна.

Конвенцийн 17 дугаар зүйлд аль нэг улсаас гадаад улсад хүүхэд үрчлэх асуудлыг маш нарийн зохицуулж өгсөн.

Үүнд: Хүүхдийг үрчлэн авах эцэг эхэд нь даалган хүлээлгэж өгөх шийдвэрийг хүүхдийн төрөлх улсад доорх тохиолдолд гаргана:

(а) тухайн улсын эрх бүхий төв байгууллага үрчлэн авах гэж буй эцэг эхийн зөвшөөрлийг баталгаажуулсан;

(b) хүлээн авагч улсын эрх бүхий төв байгууллага буюу тус улсын хуулиар болон төрөлх улсын эрх бүхий төв байгууллага тийм шийдвэрийг зөвшөөрсөн;

(c) хоёр улсын эрх бүхий төв байгууллага үрчлэлтийн явцыг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн;

(d) 5 дугаар зүйлийн дагуу үрчлэн авах эцэг эх нь үрчлэн авах боломжтой

бөгөөд хүүхэд хүлээн авагч улсад байнга оршин суух зөвшөөрөлтэй, эсхүл нэвтрэх зөвшөөрөлтэй гэдэг нь тогтоогдсон иргэдэд хүүхдийг үрчлүүлдэг.

Конвенцид Үрчлэлтийг хүлээн зөвшөөрөгч улс орнуудад зөвхөн хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангасан тохиолдолд л эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүүхдийг үрчлүүлэхээр тусгасан.

“Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудал”-аар 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдан 1995 оны 5 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон конвенцийг мөн хүүхэд үрчлэлтийн асуудалд мөрдлөг болгож байна.

- *Хүүхдийг өв тэгш хөгжүүлэх үүднээс тэднийг гэр бүлийн болон баяр баясгалан, хайр ойлголцлын орчинд өсгөн хүмүүжүүлэхийг хүлээн зөвшөөрч,*
- *Улс бүр хүүхдийг төрсөн гэр бүлийн халамжинд байлгах зохистой арга хэмжээ тэргүүн ээлжинд авч хэрэгжүүлэхийг уриалж,*
- *Төрөлх улсад нь үрчлэн авах тохиромжтой гэр бүл олдохгүй тохиолдолд хүүхдийг улс хооронд үрчлэх нь байнгын гэр бүлийн харгалзан үзсэнээр үрчлүүлж буй хүүхдэд тааламжтай байдал олгохыг хүлээн зөвшөөрч,*
- *Улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, үндсэн эрхийг нь хүндэтгэж, хүүхэд худалдах, хулгайлах, хил дамнан худалдахаас сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатайг ухамсарлаж,*
- *Олон улсын баримт бичгүүдэд тусгагдсан зарчмууд, тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенц,*
- *Хүүхэд хамгаалал, хүүхдийн аж байдлын талаар үндэсний болон улс хооронд хүүхдийг асрамжид шилжүүлэх нийгмийн болон эрх зүйн зарчмуудын тухай Нэгдсэн Үндэсний Байгууллагын тунхаглал (Ерөнхий Ассамблейн 1986 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 41/85 тоот тогтоол)-ыг харгалзан үзэж энэхүү конвенцийг нэгдэн орсон улсууд нь баталсан байна.*

Хүүхэд үрчлэлтийн асуудалд маш нухацтай анхааралтай ханддаг улсуудад Европын улсууд орж байна. Олон улсын хэмжээний үрчлэлт 1980,1990 онд нэлээд өссөн байна. Хойд Америк болон Баруун Европын орнууд гол төлөв Хятад, Бүгд Найрамдах Солонгос Улс, Зүүн Европын зарим орноос хүүхэд үрчлэн авдаг. Англи, Канад, Авсрали, АНУ-д хүүхэд хамгааллын бие даасан тогтолцоо, бүтэц механизмтай байна.

Харин Швед, Финлянд, Дани, Бельги, Голланд, Германы хүүхэд хамгааллын тогтолцоо нь гэр бүлд үйлчлэх байгууллагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт багтдаг.

Япон, Сингапурын хүүхэд хамгааллын тогтолцоо нь төвлөрсөн удирдлагатай Засгийн газрын бүрэлдэхүүнд багтдаг. Шведийн хүүхэд хамгааллын тогтолцоо нутгийн удирдлагад хамааралтай. Хүүхдийг үрчлэх үрчлүүлэх тухай асуудлыг хуулиндаа тусгахдаа нийгмийн хамгааллын тогтолцоог нь давхар тусган өгдөг.

Нийгмийн хамгааллын асуудалд АНУ болон Өндөр хөгжилтэй Баруун Европын улсууд анхааралтай хандаж, үр дүнтэй олон аргуудыг хэрэглэсээр байна. Үрчлэлтийн

асуудлаар зарим орны туршлага болон эрх зүйн зохицуулалт ямар байдаг талаар авч үзье.

Франц Улс

Гэр бүлийн хуулинд Улс хооронд болон улс дотроо хүүхэд үрчлэлтийн асуудлыг тусган дараах тохиолдолд үрчлэлтийг зөвшөөрдөг.

- Ганц бие болон гэрэлсэн хүмүүс хүүхэд үрчилж авах ;
- Ижил хүйстэн хүмүүс хүүхэд үрчлэн авах;
- Хүүхэд өргөж авах хүн нь 28-аас дээш насны байх, хүүхдээсээ дор хаяж 15 насаар ахмад байх ;
- 13 болон түүнээс дээш насны хүүхдийг авах зэрэг асуудал орно.

Хүүхдийн эрхийн конвенцид 1990 онд , Улс хоорондын хүүхэд үрчлэх конвенцид 1998 онд, Улс хоорондын хүүхэд үрчлэх конвенцид 1998 онд тус тус нэгдсэн байна. Шүүх болон хүүхэд үрчлэлтийн дээд консул нь хүүхэд үрчлэх зөвшөөрлийг өгдөг. 2004 оны байдлаар нийт 4445 хүүхэд үрчилснээс 450 нь дотоодоос, 3995 хүүхдийг гадаадаас үрчилсэн байна.

Хүүхэд үрчлэлтийн асуудлыг зөв зохистой шийдвэрлэхэд хүүхдийн тэтгэлэг гол үүрэгтэй гэж үздэг. Гэр бүлийн тэтгэмжийн сан, Эрүүл мэндийн сангаар дамжуулан тэтгэмж, тэтгэлэг олгодог бөгөөд тэтгэмжинд хамрагдахын тулд хүүхэд үрчлэлтийн асуудлаар 20-иос доош насны нэг болон түүнээс дээш хүүхэд үрчилж авсан, хэдэн хүүхэд үрчлэн авах тухай тоо болон хүсэлтийг дээрхи байгууллагад гаргаснаар хэрэгжинэ. Шинэ төрсөн хүүхдийн хувьд Жирэмсэний 7 сарын хугацаанд 855.25 евро олгодог бол үрчилж авсан болон үрчилж авахаар тогтсон хүүхэдтэй тохиолдолд 1710.49 евро олгодог.

Бүгд Найрамдах Солонгос Улс

Солонгосын гэр бүлийн хуулинд хүүхэд үрчилж авахдаа өөрийн улс дотроо болон гадаад улсаас, ганц бие эх болон эцгийг, 15 наснаас дээш насны хүүхдийг авахыг зөвшөөрдөг харин хүүхэд үрчилж авах эцэг эхийн нас 25-50 байна. 1991 онд Хүүхдийн эрхийн конвенцид нэгдсэн. Шүүх болон эрүүл мэнд нийгмийн хамгаалалын яам нь хүүхэд үрчлэх эрхийг олгодог байгууллага юм. 1999 оны сүүлээр дан ганц улс дотроо хүүхэд үрчлэлтэй холбоотой асуудлыг хариуцдаг байгууллага 22 байсан бол гадаад улс орны хүүхэд үрчлэлтийг давхар хариуцсан 4 байгууллага бий болсон юм.

Эдгээр байгууллагаар дамжуулан улс дотроо 1716 хүүхэд, харин гадны улс оронтой холбоотой 2409 хүүхэд үрчлэгдсэн байна. Гадаадын иргэн 28000 мянган вон төлж хүүхэд үрчлэн авдаг.

Улс доторх хүүхэд үрчлэлтийг дэмжихийн тулд засгийн газар 2000 оноос эхлэн хүүхэд үрчлэлтийг талаар олон нийтийн хэвлэл мэдээллээр сурталчилж, хүүхэд үрчилж авах зуучлалын хөлсийг улс хариуцаж (зуучлалын хөлс ойролцоогоор нэг хүүхэд 2 сая вон) хүүхэд үрчилж авч байгаа хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тэтгэмж (хүүхэд өсгөх тэтгэмж 100 мянган вон сар бүр, нэг хүүхдэд) олгохоор зохицуулсан.

Мөн хүүхэд үрчлэлтийн тогтолцоог шинэчилж бага орлоготой гэр бүлд хүүхэд үрчилж авах боломж олгох үүднээс хууль эрх зүйн шинэчлэлийг хийж (гэр бүлд шаардагдах хөрөнгийг хэмжээг багасгах) эцэг эхийн насны байдлыг 25 наснаас дээш байсныг 20 наснаас дээш байхаар, гэрлээд 3 жил болсон, 4-өөс дээш хүүхэдгүй байхаар заасан.

Хүүхэд үрчлэлтийг дэмжиж өргөжүүлэх зорилгоор 5 дугаар сарын 11-ний өдрийг “Хүүхэд үрчлэлтийн өдөр” болгож, энэ өдрөөс эхлэн 1 долоо хоногийн хугацаанд явагдах төрийн болон орон нутгийн байгууллага нь үрчлэлтийн өдрийн үйл ажиллагаанд идвэхтэй оролцохыг уриалсан төдийгүй, Улсаас хүүхэд үрчлэлтийн дараах үйлчилгээний байдал, улс доторх хүүхэд үрчлэлтийг өрнүүлж өргөтгөх асуудлыг дэмжин, хүүхэд үрчлэлтийн байгууллагыг шаардлагатай мэдээлэлээр хангах мэдээллийн системийг бүрдүүлэхэд онцгой анхаарсан байна.

Гадаад улсад хүүхэд үрчлэх явдлыг багасгах бодлого барьж, Гадаадын иргэн хүүхэд үрчлэлтийн байгууллагын дарга байж болохгүйг хуулинд оруулсан.

Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайд нь улс доторх хүүхэд үрчлэлтийг дэмжих, өргөжүүлэх, үрчлэлтийн дараах үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор Улсын хүүхэд үрчлэлт эрхэлсэн хороог байгуулж удирддаг бөгөөд тус байгууллага нь хууль ёсны сантай байна. .

Швед Улс

Швед нь хүүхэд эхэд ээлтэй орон бөгөөд 12-оос дээш насны хүүхдийг эх орондоо болон гадаадад үрчлүүлэх, гадаадаас болон улс дотроо хүүхэд үрчлэн авах, ганц бие эмэгтэй, эрэгтэй аль нь ч хүүхэд үрчлэн авч болох ба 25-аас дээш насны гэр бүлийг хүүхэд үрчлэн авахыг зөвшөөрдөг.

1990 онд Хүүхдийн эрхийн конвенци, 1997 онд Улс хоорондын хүүхэд үрчлэх конвенцид нэгдэн орсон. Хүүхэд үрчлүүлэх Үндэсний төв болон Шүүх нь хүүхэд үрчлэх эрхийг олгодог байна. 2004 оны байдлаар нийт 1669, үүнээс дотооддоо 576, гадаадад 1093 хүүхэд үрчлүүлсэн байна.

1930 оноос төрөлт багассантай холбоотой эх хүүхдийн асуудлыг маш их анхаарч хүүхэд төрүүлэх, үрчлэн авах, асран хамгаалахтай холбоотой асуудалд засгийн газраас олон үе шаттай арга хэмжээ авч ирсний үр дүнд нааштай үр дүнд хүрсэн. Мөн үүнтэй холбоотой олон бэрхшээл гарч ирсэн.

Хүүхэдтэй гэр бүл болон хүүхэдгүй боловч 28-аас доош насны залуу гэр бүлд орон байрны тэтгэмж олгодог. Үүнд хүүхэд үрчилж авсан гэр бүл мөн хамрагддаг.

Хүүхэдтэй гэр бүлийн хувьд орон байрны тэтгэмжийн хэмжээ нь орлогоо дагаад ялгаатай байна.

1975 оноос хүүхдээ асарч өсгөх нь хүүхэд бүрийн эдлэх эрх болгон журамлаж сургуулийн өмнөх насны хүүхдийн суурь үйлчилгээг нэвтрүүлсэн. Хүүхэд үрчлэн авсан үед аавын амралт гэж олгодог. Хүүхэд төрүүлэх, үрчлэн авах тохиолдолд эцэг болсон хүн 10 хоногийн аавын амралт (paternity leave) авч болдог. Мөн 2001 оны 7 сараас эхлэн онцгой тохиолдолд аавын оронд гуравдагч этгээд авч болохоор зохицуулжээ. Аавын амралт нь хүүхэд төрсөн, үрчлэн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор ашиглах боломжтой, орлогын 80 хувийг олгодог.

Швед улсын хүүхэд өсгөх байдлыг дэмжих бодлогын хэлбэр

Хэлбэр	Агуулга
Үндсэн хөлс	Хүүхдийн цалин (Олон хүүхэдтэй гэр бүлийн тусламж, хүүхэд үрчлэх тэтгэмж орно)
Нийгмийн халамж	Нярай хүүхдийн амралтын мөнгө Өвчтэй хүүхэд асрах амралт Хүүхдийн тэтгэвэр Жирэмсний болон төрсний тэтгэмж Хүүхэд харах хугацаанд тэтгэмж авах эрхтэй
Орлогын судалгаа болон шаардлагатай судалгааны хөлс	Ганц бие эцэг, эхтэй гэр бүлийн тэтгэмж Орон байрны тэтгэмж Хүүхэд хамгаалах тэтгэмж

Ганц бие эцэг эхтэй гэр бүл хүүхэд үрчлэн авсан тохиолдолд хүүхдээ өсгөх тусламжийн мөнгийг нийгмийн даатгалын сан өгнө. Хэрэв эцэг эхийн нэгэн дээр өсөж байсан хүүхдээ үрчлүүлвэл үрчилж авсан гэр бүлд тусламжийн мөнгийг зайлшгүй өгөх ёстой болдог.

Хойд Европын нийт орнууд, Финлянд, Шинэ Зеландад төрөх болон өргөж авахтай холбоотой хөрөнгө санхүүгийн хангамжтай холбогдуулан төрсний дараа, өмнөх хугацааны аль нэгэнд нь төрөлттэй холбоотой мөнгөн тэтгэмж өгдөг. **Финляндад 17-оос доош насны хүүхдэд тэтгэмж өгдөг. Энэ нь засаг захиргааны тэтгэмж ба амьжиргааны тэтгэмж байдаг. орон нутгийн засаг захиргааны тэтгэмж нь орлого багатай гэр бүлд хамрагдана.** Амьжиргааны тэтгэмжийг өргөмөл хүүхэд авч болдог. Тэтгэмжийг хүүхдэд зарцуулагдах ёстой ба өөр зүйлд зарцуулсан бол татан хураадаг.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятадад үрчилж авах эцэг эхийн нас 30 хүрсэн байх ба 55 наснаас дээш настай бол зөвшөөрдөггүй, заавал дунд сургууль төгссөн байхыг шаарддаг. Жилийн орлого нь 10 мянган доллар байна, 4 хүүхдээс дээш бол болохгүй, бага хүүхэд нь 1 настай байх юм бол хүүхэд үрчилж авч болно. Гэр бүлийн нийт хөрөнгө нь 80 мянган ам долларт хүрсэн байх ёстой, гэмт хэрэгт ороогүй, архи хэрэглэдэггүй, сэтгэц эрүүл, эрхтэн бүтэн байх ёстой гэж хуульчилжээ. Гадаадын иргэд 19-23 мянган доллар төлж, жилд улсад төлөх татвараасаа 11 мянга 390 долларын татвараас чөлөөлөгдөг.

Америкийн иргэн Хятадаас хүүхэд үрчлэн авахдаа хуулинд заасан материалыг бүрдүүлэхийн хамт Холбооны мөрдөх товчооны тодорхойлолтыг заавал авчрах ёстой. Хятадад хэрэв хүүхэд гэр бүлийн хүчэрхийллийн улмаас эмнэлэгт ирвэл цагдаа эрүүгийн хэрэг үүсгэн эцэг эх байх эрхийг нь хасаж өөр айлд үрчлүүлэхээр хуулинд заасан байна. Хятад улсад хүүхэд үрчлэлт нэлээд өндөр байдаг.

Бельги улс

Бельгид дотоод гадаад үрчлэлтийг хүлээн зөвшөөрөх төдийгүй ганц бие хүн хүүхэд үрчлэн авахыг зөвшөөрдөг. Харин 12-оос дээш насны хүүхдийг үрчлүүлдэг. 1991 онд Хүүхдийн эрхийн конвенцид нэдэн орсон. Бельгид хүүхэд үрчлэн авсан эцэг эхэд улсаас үзүүлэх тэтгэвэр тэтгэмж нь хүүхэд төрүүлсэн эцэг эхэд үзүүлдэг тэтгэвэр тэтгэмжтэй адил хүүхэд эхийн асуудалд нааштай ханддаг орны тоонд ордог. Европын хүүхэд үрчлэлтийн асуудлаархи конвенцид бас нэгдэн орсон улсын нэг юм. Бельги нь хүүхдэд ээлтэй орны тоонд орж тэтгэмж маш сайн өгдгөөрөө Европод нилээд дээгүүрт ордог.

Оросын Холбооны улс

ОХУ-д хүүхэд үрчлэлтийг дотоод болон гадаад улс оронд үрчлүүлэхийг зөвшөөрдөг. Ганц бие эх болон эцгийг хүүхэд авахыг зөвшөөрдөг төдийгүй 10 наснаас дээш насны хүүхдийг үрчлүүлдэг. 1990 онд Хүүхдийн эрхийн конвенцид нэгдсэн. Шүүх нь хүүхэд үрчлэх эрхийг олгодог. 2004 оны хувьд нийт 23108 үүнээс дотооддоо 17331, гадаадад 5777 хүүхэд үрчлүүлсэн байна. 2004 оны байдлаар 100 000 төрөлт тутамд 1656 хүүхэд үрчлэгдсэн байна. Ер нь ОХУ-д хүүхэд үрчлэлийн төвшин маш доогуур байдаг бөгөөд 2009 оны байдлаар 3400 гаруй хүүхдийг үрчилсэн тоо гарсан.

Эдгээр хүүхдүүдээс гуравны нэг нь АНУ-ын гэр бүлд үрчлэгдсэн аж. Харин 2010 онд хамгийн их хүүхдийг үрчилж авсан байдаг. Тухайн үед ойролцоогоор АНУ-ын зүгээс ОХУ-д гэр оронгүй, хөгжлийн бэрхшээлтэй 4000 гаруй хүүхдүүдийг үрчлэн авчээ. ОХУ-ын зүгээс ч хүлээн зөвшөөрдөг байсан боловч үрчлэгдсэн хүүхдүүдийн эрх ихээр зөрчигдөх болсон маргаанаас үүдэн Оросын өнчин хүүхдүүдийг АНУ-ын иргэдэд үрчлүүлэх нь үндэстэн ястны ирээдүй хөгжилд чухал нөлөө үзүүлнэ гэж Оросын хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага үзсэн байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин дээрх асуудлыг нухацтай авч үзэн анхаарлаа хандуулж, зүй зохистойгоор шийдвэрлэх, энэ талаар зохих хууль журмыг батлах үүргийг өгснөөр Төрийн Дум хөгжлийн бэрхшээлтэй, гэр оронгүй гэх мэт ер нь орос хүүхдүүдийг АНУ-ын ямар ч иргэдэд үрчлүүлэхийг хориглосон хуулийн төслийг гурван удаа хэлэлцэж 2013 онд эцэслэн батлан гаргасан. Хуулийг 420 депутат дэмжиж, долоон хүн эсрэг санал өгчээ.

Герман Улс

Улс хоорондын хүүхэд үрчлэх холбооны төв байгууллага болон шүүхийн шийдвэрээр хүүхэд үрчилж авахыг зөвшөөрдөг. Гэр бүлийн хуулинд өөрийн улс дотроо болон гадаад улсаас, Ганц бие эх болон эцгийг, 14 болон дээш насны хүүхдийг үрчлүүлэх, 21 настай болон түүнээс дээш насны эцэг эх байхыг хуульчилсан.

1992 онд Хүүхдийн эрхийн конвенцид, 2001 онд улс хоорондын хүүхэд үрчлэх конвенцид нэгдсэн. 2004 оны байдлаар гэхэд нийт 5668 хүүхдийг, үүнээс улс дотроо 3749, гадаад улсад 1919 хүүхэд үрчлүүлсэн байна. 2004 оны байдлаар 100000 төрөлт тутамд 797.4 хүүхэд үрчлэгдсэн байна. Хүүхдийн тэтгэлэгийг төрсөн хүүхдийн адил хэмжээнд үзэж хангалттай хэмжээнд олгож, цалингийн өөрчлөлт тутамд нэмэгдүүлдэг.

Япон Улс

Япон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага болон шүүхийн шийдвэрээр өөрийн улс дотроо болон гадаадаас хүүхэд үрчилж авахыг зөвшөөрдөг. Гэр бүлийн хуулинд нь ганц бие эх болон эцгийг хүүхэд авахыг зөвшөөрч хүүхэд үрчлэн авах ганц бие эцэг эхийг 25-аас дээш настай байхаар, гэр бүл болсон бол 20 болон түүнээс дээш настай байхаар заасан. Үрчилж авах хүүхдэд нас заагаагүй

1994 онд Хүүхдийн эрхийн конвенцид нэгдсэн боловч Улс хоорондын хүүхэд үрчлэх конвенцид нэгдээгүй. Гадаадад үрчлэлт явагдах нь бага байдаг. 2004 оны байдлаар нийт 1931 хүүхэд үрчлэгдсэнээс гадаадад 299 хүүхэд үрчлүүлсэн байна. Хүүхдийн тэтгэлэгийг үрчилж авсан хүүхэдтэй гэр бүл төрүүлсэн хүүхэдтэй гэр бүлийн адил авах эрхтэй.

Вьетнам Улс

Вьетнам улсын Хууль зүйн яам, Ардын холбоо нь өөрийн улс дотроо болон гадаад улсаас хүүхэд үрчлэн авах ба үрчлүүлэх асуудлыг хариуцдаг. Ганц бие эх болон эцгийг 9 наснаас дээш насны хүүхэд үрчлэн авахыг зөвшөөрдөг. Үрчлэн авч буй хүүхдээсээ 20 насаар илүү байхад хүүхэд үрчлэлтийн асуудлыг зөвшөөрдөг. 1990 онд Хүүхдийн эрхийн конвенцид нэгдсэн, Хууль зүйн яам, Ардын холбоо нь хүүхэд үрчлэх эрхийг олгодог байгууллага юм. 2004 оны байдлаар нийт 2881 үүнээс дотооддоо 1462, гадаадад 1419 хүүхэд үрчлүүлсэн байна. Гадаадын иргэдийг үрчилж авсан хүүхэд нь эсэн мэнд бойжиж байгаад хяналт тавих зорилгоор 2 жилээс доошгүй хугацаанд хүүдийн асуудал эрхэлсэн байгууллагад тайлагнаж зарим тохиолдолд тус улсад өөрийг нь авчирч үзүүлж байх шаардлагыг зарим улс орнуудад тавьдаг байна.

Англи Улс

Тус улсын Шүүх нь хүүхэд үрчилж авахыг доорх тохиолдолд зөвшөөрөл олгоно.

- Өөрийн улс дотроо болон гадаад улсаас
- Ганц бие эх болон эцгийг
- 21 наснаас дээш насны эцэг эхэд

1991 онд Хүүхдийн эрхийн конвенцид, 2003 онд улс хоорондын хүүхэд үрчлэх конвенцид нэгдсэн. 2002 оны хувьд нийт 6239 үүнээс дотооддоо 5910, гадаадад 329 хүүхэд үрчлүүлсэн байна. 2002 онд 100000 төрөлт тутамд 923 хүүхэд үрчлэгдсэн байна.

Америкийн Нэгдсэн Улс

Өөрийн төрсөн гэр бүлтэйгээ эргэж амьдарч чадахгүй болсон хүүхдийг үрчлүүлэхийг улс орнуудын засгийн газар бодлогоор дэмждэг болохыг эрдэмтэдийн хийсэн судалгаа үзүүлсэн байна. Тухайлбал, АНУ-д гэхэд 2002 онд Клинтон улсын асрамжинд байгаа хүүхдүүдээс үрчлүүлэх хүүхдийн тоог 2 дахин нэмэгдүүлэхийг уриалсан байна. 1997 онд батлагдсан хүүхэд үрчлэх болон гэр бүлийн аюулгүй байдлын хуулинд хүүхэд үрчлэхийг дэмжсэн байдаг ба хүүхэд өргөж авсан хүнд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлсэн байдаг.

Ерөнхийлөгч Буш хүүхэд үрчлэлтийг дэмжиж байсан байдаг. 2002 онд Хүүхэд үрчлэх хуульд хүүхдийн тэтгэлэгийг хамгийн чухал үзүүлэлт болгон авч үзсэн. Америк иргэд Азиас, Өмнөд Америк, Хятад, Солонгос, Вьетнамаас хүүхэд үрчлэн авдаг. Хүүхэд үрчлэлтээр дээгүүр ордог тэргүүлэгч улс ч гэж хэлж болно. Хүүхдийн эрх, хүний эрхийг маш их дээдэлдэг улсын хувьд хүүхэд үрчлэлтийн асуудалд анхааралтай хандаж улсаас олгодог тэтгэмжийг янз бүрийн сангуудаар дамжуулан өгдөг. Холбооны улсаас өгдөг тэтгэлгүүдэд үрчлэгдсэн хүүхдүүдийн тэтгэвэр өөр өөрөөр тусгагддагч хүүхэд бүрийг хамруулах, ялгаварлан үзэхгүй байхыг хуулиар зохицуулдаг.

Монгол Улс

Монгол Улсын гэр бүлийн хуулийн 7 дугаар бүлэг бүхэлдээ хүүхдийн эрх ашиг сонирхлын үүднээс үрчлүүлэх харилцааг зохицуулдаг. Монгол Улс Хүүхэд хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцэд 1999 онд нэгдсэнээс хойш 239 хүүхдээ гаднын улсын гэр бүлд үрчлүүлээд байна.

2001 онд гаргасан гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журам гарсан ба журмын 2.15-д Үрчлэн авсан хүүхдийн талаар 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл 2 жил тутам Монгол Улсын гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд мэдээлэл ирүүлэх, 2.15-ын г/д Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын эрх бүхий байгууллагаас хүүхдийн аж байдалтай танилцах, түүнтэй ярилцах боломжоор хангах гэж заасан.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд Гадаадад хүүхэд үрчлүүлэх асуудал хариуцсан зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тушаалыг 2012 оны 12 дугаар сард гаргасан. Гадаадад хүүхэд үрчлүүлэх харилцааг манай улсад Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба хариуцдаг. Манай төр засаг монгол хүүхэд монгол гэр бүлд өсөх ёстой гэсэн бодлого барьдаг.

Манай улс АНУ, Герман, Канад, Голланд, Австрали, Япон, Итали, БНСУ, Англи, Бельги, Дани, Франц, Испани, Финланд, Нидерландад хүүхэд үрчлүүлжээ.

Эдгээрээс АНУ-д хамгийн олон буюу 149, Германд 29, Францад 19, Италид 11 хүүхэд үрчлэгдэн амьдарч байна. 1999 онд анхны монгол хүүхдийг АНУ-д үрчлүүлсэн бол түүнээс хойш 2000- 2003 онд жилд хамгийн олон буюу 25-35 хүүхэд үрчлүүлсэн байна. “Түүнээс хойш гадаадад үрчлүүлсэн хүүхдийн тоо жил ирэх тусам буурч байгаа юм байна.

ДҮГНЭЛТ

Хүүхэд үрчлэн авах, үрчлүүлэхтэй холбоотой асуудлыг судлах явцад Хүүхдийн хамгаалал бол хүүхдийн сайн сайхантай холбоотой бүх асуудалтай нягт уялдаатай бөгөөд хүүхдийн бүхий л эрхийг хамгаалах орчинд явагдах ёстой гэж үздэг.

Эрдэмтдийн судалгаагаар өөрийн төрсөн эцэг эх, төрсөн гэр орондоо цаашид амьдрахгүй болсон хүүхдийн асуудал бол үрчлэх ба үрчлүүлэхтэй холбоотой асуудал гэж дүгнэжээ.

Өнөөдөр энэ асуудал дэлхийн олон нийтийн анхаарлын төвд байна. Гэсэн ч дэлхийн олон улсад хүүхдийн эрх тэр бүр хангагдаж чадахгүй зөрчигдсөөр байна.

Олон хүүхэд хил дамнан худалдаалагдаж байна. Жил болгон 1.2 сая хүүхэд худалдаалагдаж байгаа судалгаа байдаг.Цаг хугацаа явах тусам хүүхэд үрчилж авах зорилго өөрчлөгдсөөр байна.

19 дүгээр зууны дунд үе хүртэл хүүхдэд тэтгэлэг өгдөггүй байсан ба үрчилж авсан хүүхдэд хүүхэд өсгөхөд зориулж янз бүрийн хэлбэрээр тэтгэлэг өгдөг болсноор хүүхэд өргөж авах нь илүү утгатай, өргөн хүрээтэй гэр бүлд эдийн засгийн дарамт багатай болж байна.

Ойролцоогоор 160 улсад хүүхэд үрчлүүлэх институттэй байдаг бол 20 орчим улс хүүхэд үрчлэх хуулийн орчингүй байдаг. Зарим улс орнуудад албан ёсоор хүүхэд үрчилсэнээс албан бусаар хүүхэд үрчлэхийг илүүд үздэг.

Үрчлэгдсэн хүүхдийн эрх нь улс орнуудын хувьд өөр өөр байдаг байна. Зарим улсад үрчлэгдсэн хүүхэд нь өөрийн төрсөн хүүхэдтэй яг ижил эрхийг эдэлдэг, заримд нь арай ялгавартайгаар зохицуулагдсан.

Хүүхэд өргөж авах эцэг эхэд тавигдах шаардлага нь улс бүрийн хувд янз бүр 81 улсад хүүхэд өргөж авах эцэг эхийн доод насыг заасан байдаг бол 15 улсад дээд насыг нь хуульчлан заасан байдаг. 100 улс оронд ганц бие хүнийг хүүхэд үрчилж авахыг зөвшөөрдөг бол 15 улсад заавал гэрэлсэн хүн байх ёстой гэж заасан байна.Хүүхэд үрчлэлтийн 85 хувь нь улс дотроо хүүхэд үрчилдэг байна.

Улс хооронд хүүхэд үрчлэлт сүүлийн үед нэмэгдэж байгаа хандлага ажиглагдаж байгаа төдийгүй ялангуяа Европын улсуудад нэмэгдэж байна. Үрчлэгдэж буй

хүүхдүүдийн 60 хувь нь 5 наснаас доош насны хүүхэд байгаа боловч охидүүдыг хөвгүүдээс илүү их үрчлүүлдэг.

Өөрийн хүссэн тооны хүүхэд гаргаж чадахааргүй гэр бүл хүүхэд үрчлэх нь илүүтэй байдаг ба үрчлэн авч байгаа эцэг эхчүүдийн ихэнх нь 30-44 насны ангилалд багтдаг. ДОХ-ын улмаас эцэг эх нь нас барсан хүүхдүүд ихээр өнчирөн хоцорч өргөгддөг байна.

Дэлхийн улс орнуудад хүүхэд үрчлэлтийн асуудалд үүсэж ба

йгаа зарим сөрөг нөлөөллийг дурьдвал:

- Хүүхэд үрчилж авахыг ихэд сонирхож буй хүүхэдгүй гэр бүлийн тоо/ хэрэгцээ/ өсөн нэмэгдэж байгаа явдал,
- Зарим гэр бүл, ялангуяа ганц бие ядуу эмэгтэй хангалуун амьдралаар тэжээн тэтгэж чадахгүй байгаа зовлонгоо гэтлэх цорын ганц арга бол бусдад хүүхдээ үрчлүүлэх нь асуудлыг шийдэх гарц гэж үзэх болсон,
- Дэлхийн зарим хэсэгт хүүхэд үрчлэх асуудалд уламжлалт ёс заншил саад болдог нь хүүхэд үрчилж авах гэр бүл олдохгүй цөөрөхөд хүргэдэг сөрөг нөлөөлөл
- Хүүхэд үрчлэн авах зорилго агуулга өөрчлөгдөж түүнийг өөр зорилгод ашиглах явдал нэмэгдэж байгаа зэрэг асуудлууд орж байна.

Урьд нь гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх зориолгоор үрчлэлтийн асуудал явагддаг байсан бол сүүлийн үед хэрэгцээ талаас нь хардаг болсон.хүүхдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэх тусам түүнийг тойрсон хил дамжуулан худалдах зэрэг хор уршигтай хууль бус үйл ажиллагаа ихэсдэг.

Дээрх сөрөг нөлөө нь ядуу гэр бүл бат бэх амьдарч чадах байсан ч салж сарнихад нөлөөлдөг, Нялх хүүхдийг үрчлүүлэх зорилгоор хил дамжуулан худалдаалах явдлыг өөгшүүлдэг. Жил бүр Ази, Төв болон Зүүн Европ, латин Америкийн орнуудаас 20000 орчим нялх хүүхдүүд хөгжингүй орнуудад үрчлэгддэг ба дээрхни орнуудад эрүүл хүүхэд үрчлэн авах эрэлт хэрэгцээ улам нэмэгдэж байгаа юм байна.

Иран, Алжир, Израйл, судан, Нигери улсад хүүхэд үрчлэлтийг зөвшөөрдөггүй. Ер нь лалын шашинтай улсууд хүүхэд үрчлэлтийг зөвшөөрч дэмждэггүй юм байна.

Хүүхэд үрчлэлтийн асуудлыг нэг мөр болгон шийдэх, хүүхдийн эрхийг хүндэтгэн үзэх, хүүхдийн эрхийг бүдүүлгээр зөрчиж байгааг буруушаасан олон нийтийн шаардлага, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, төрийн бус байгууллага, хүний эрхийн байгууллагаас үзүүлж буй шахалтын улмаас зарим улс хооронд үрчлэлтийн асуудалд маш их анхаарч хуулиндаа өөрчлөлт оруулж зарим улсууд гадаадад үрчлүүлэх асуудалд хориг тавьжээ

Үүнтэй уялдан улс хоорондын үрчлэлтэй холбоотой хүүхдийн эсрэг доромжлолыг онцлон заасан хэд хэдэн зөвлөмжийг Олон улсын Хүүхдийн эрхийн хороо гаргаад байгаа юм байна.

АНУ-ын Нийгэм Эдийн засгийн яамнаас явуулсан судалгаанаа дараахь тоог гаргажээ. Жил бүр ойролцоогоор 250000 хүүхэд үрчлэгддэг бөгөөд дэлхийн цөөн хэдэн улс хүүхэд үрчлэлтийн ихэнх хувийг эзэлдэг. АНУ-д 2001 онд 127000 хүүхэд үрчилсэн ба дэлхийн хүүхэд үрчлэлтийн тал хувийг эзлэж байна.

Түүний дараагаар Хятад 46000, ОХУ 23000 хүүхэд үрчлүүлсэн байна. Дэлхийн улсуудын энэ асуудалд хандаж байгаа хандлагаас харахад дотооддоо хүүхэд үрчлүүлэх болдлогыг илүү дэмжиж, эдийн засгийн асуудлыг нь давхар шийдсэнээр хүндрэл үүсэхгүй гэж үздэг юм байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах талаар гарсан хууль тогтоомж, дүрэм журам, конвенцид нэгдэн орсон улсуудын үүргээ хэрхэн биелүүлж байгаад анхаарал хандуулж, гол үүрэг гүйцэтгэгч болж байгаа байгууллага бол НҮБ-ийн Хүүхдийн сан юм.

Манай улсад энэ байгууллага хүүхдийн эрхийг хамгаалах талаар санаачлагатай сайн ажиллаж олон төсөл хэрэгжүүлэн, хүүхдийн эрхийн байгууллагуудтай хамтран хурал семинар зохион байгуулж үр дүнд хүрч байгаа талаар Монголын Хүүхдийн байгууллага, Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа Төрийн бус байгууллагуудаас гарсан баримт бичиг, дүгнэлт, тайланд тусгасан байна.

Ашигласан материал

1. Хүүхэд хамгаалал. Парламент хоорондын холбоо. УБ хот.
2. Хүүхдийн эрхийн конвенци 1993 он
3. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлын тухай конвенци, 1995 он
4. Монгол Улсын гэр бүлийн тухай хууль, 1999 он.
5. БНСУ-ын улсын гэр бүлийн тухай хууль сургалтын гарын авлага, Улаанбаатар Их Сургууль, 2011 он
6. //http://www.portal-deti -semya.ru/
7. //http://www.gov.ros.